

АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН  
2019.03.04-2019.03.08 ӨДРИЙН МЭДЭЭ

№	Долоо хоногт хийж хэрэгжүүлсэн ажил	дараа долоо хоногт хийх ажил
1	<p>Өвөлжилт, хаваржилт хүндэрч малын зүй бус хорогдол ихэсч байгаатай холбоотой үхсэн малын мах худалдан авах, худалдаалагдах, бэлтгэн нийлүүлэгдэхээс урьдчилан сэргийлж зорилгоор Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 04/89 дугаартай урьдчилан сэргийлэх удирдамжийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх явцад үхсэн малын мах хадгалж байсан нэг иргэний зөрчлийг илрүүлж, нийт 500 кг махыг хураан авч эзнийг байлцуулан Өлгий хогийн цэгт шатааж устган, Зөрчлийн тухай хуулийн 6.15 дугаар зүйлийн 3.1 дэх заалтын дагуу 500 000 /таван зуун мян/ төгрөгийн шийтгэвэр ногдуулж барагдууллаа</p>	
2	<p>Баян-Өлгий аймгийн хэмжээнд өвөлжилт хүндэрч бэлчээр хомстож мал өл алдах, осгох, тураалд орох зэргээр малын зүй бус хорогдол ихэсч байгаатай холбоотой үхсэн малын мах худалдан авах, худалдаалагдах, бэлтгэн нийлүүлэгдэхээс урьдчилан сэргийлж зорилгоор Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 04/42 дугаартай урьдчилан сэргийлэх удирдамжийн хүрээнд мал төхөөрөх Нөхөд ХХК, Угур ХХК, Азат ХХК, Еттаранзит ХХК, Тирлик, Ахдам зах, Тирлик захад үйл ажиллагаа явуулж буй гуанз, цайны газрууд, Аборжан, Алтаннутаг, Дастархан хиамны цехүүд, Өлгий сумын хүүхдийн цэцэрлэгүүдийн махны, чанар аюулгүй байдал, гарал үүсэлд Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 04/42 дугаартай удирдамжаар төлөвлөгөөт бус урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж байна.</p>	
3	<p>Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 20 ны өдрийн 189 дүгээр тогтоолоор "Нэг удаагийн нийлэг хальсан уутыг худалдаа үйлчилгээнд сав баглаа боодлын зориулалтаар импортлох, үйлдвэрлэх, хэрэглэх"-ийг 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хориглосон.</p> <p>Тогтоолын хэрэгжилтийг хангуулахаар холбогдох хяналтын улсын байцаагчид хүнсний худалдаа үйлчилгээний газар, дэлгүүр, супермаркетуудад хяналт шалгалт хийж 57 ширхэг нийлэг хальсан уутыг хурааж, цаашид хэрэглэхгүй байхыг анхааруулж, зөвлөж ажилласан болно.</p>	
4	<p>Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу НИЙТ 8 ЭМИЙН САНГУУДАД УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ хяналт шалгалт хийлээ.</p> <p>Шалгалтаар жороор олгох заалт бүхий эмийг шаардлага хангаагүй жороор болон жоргүйгээр олгосон зөрчлийг үндэслэн 5 эмийн сангийн эрхлэгчийг зөрчлийн тухай хуулийн дугаа 250.000 төгрөгний шийтгэлийн арга хэмжээ авлаа.</p> <p>Шалгалтын явцад зөрчил арилгуулах чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.</p>	
5	<p>Сумдын Байгаль орчны хяналтын улсын байцаагч нар болон Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нарт хяналт шалгалттай холбоотой хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэн ажиллахтай холбоотой онол арга зүйн болон мэргэшлийн мэдлэг олгох, ур чадварыг дээшлүүлэх, харилцан</p>	

мэдээллээр хангах зорилгоор нэг өдрийн сургалтыг зохион байгуулж байна. ДАВТАН ҮЗЛЭГ ШИНЖИЛГЭЭНД ХАМААРУУЛЛАА.

Баяннуур сумын ерөнхий боловсролын сургуульд хийсэн гүйцэтгэлийн шалгалтын дүнг Мэргэжлийн хяналтын газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хурлаас гарсан шийдвэрийн мөрөөр аймгийн Эрүүл мэндийн газарт 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01/92 тоот албан бичгээр албан даалгавар хүргүүлж Баяннуур сумын сургуулийн дотуур байрны хоолны хордлогот халдварт өртсөн хүүхдүүдийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээнд давтан хамаарууллаа.

Үзлэг, шинжилгээг аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн, халдвартын, мэдрэлийн, чих хамар хоолойн, нян судлалын эмч, дүрс оношлогооны эмч нарын бүрэлдэхүүнтэйгээр хийж, нийт хоолны хордлогод өртсөн 50 хүүхэд үзлэг, шинжилгээнд хамрагдсан байна.

11 хүүхэд Улаанбаатар хотод эмчилгээ оношлогоо хийлгэхээр явсан бөгөөд үлдсэн 12 хүүхэд хичээлдээ ирээгүй хөдөө гэртээ байгаа гэх шалтгаанаар үзлэг, шинжилгээнд хамрагдаагүй ба эдгээр үлдсэн хүүхдүүдийг яаралтай хамааруулах талаар Баяннуур сумын Эрүүл мэндийн төв, аймгийн Эрүүл мэндийн газарт дахин чиглэл өглөө.

Мэдээг нэгтгэсэн:

Х.Жанар